

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

(Хамрах хугацаа: 2023.01.03-2023.03.31)

2023.04.03.

Улаанбаатар хот

Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлөөс 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 1 дүгээр улиралд гүйцэтгэсэн ажлын товч тайланг танилцуулж байна.

Нэг. Сул орон тооны сонгон шалгаруулалтын захиалгын талаар:

Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд 1 дүгээр улирлын дүнгээр салбар зөвлөлөөс төрийн захиргааны гүйцэтгэх 8 албан тушаалын сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Сонгон шалгаруулалтын газарт албан бичгээр хүргүүлж, ажлын 10 хоног байгууллагын болон Төрийн албаны зөвлөлийн цахим сайтаар нийтэд зарлууллаа.

Хүснэгт-1

№	Захиалга хүргүүлсэн албан бичгийн огноо, дугаар	Сул орон тоо		Албан тушаалын нэр
		Удирдах албан тушаал	Гүйцэтгэх албан тушаал	
1	2023.01.09 №01		6	Өмнөд бүс дэх газрын захиргааны ахлах мэргэжилтэн-1; Дорноговь аймаг дахь газрын мэргэжилтэн-2; Зүүн бүс дэх газрын мэргэжилтэн-3.
2	2023.03.02 №02		2	Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн гадаад харилцааны мэргэжилтэн-1; Баруун бүс дэх газрын Увс аймаг дахь мэргэжилтэн-1.
3	2023.03.20 №03		2	Дорноговь аймаг дахь газрын мэргэжилтэн-1; Зүүн бүс дэх газрын мэргэжилтэн-1.
ДҮН		0	10	

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаар тогтоолоор баталж, 04 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам, загвар батлах тухай” журмын 4.2-т дагуу 3 дахь удаагийн 2 гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтын зарыг төрийн жинхэнэ албан хаагчдын хүрээнд 5-аас доошгүй хоног байгууллагын цахим хуудсаар 04 дүгээр сарын 04-ний өдрийг дуустал хугацаанд зарлаад байна. Зарын дагуу албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан төрийн жинхэнэ албан хаагч бүртгүүлсэн тохиолдолд дээрх журмын дагуу нийтэд зарлахгүйгээр шууд томилохоор журмын зохицуулалттай болсон. Харин шаардлага хангасан төрийн жинхэнэ албан хаагч бүртгүүлээгүй бол ажлын 10-аас доошгүй хоног зарлах явцдаа бүртгэл хамт хийгдэх юм.

Хоёр. Албан тушаалын тусгай шалгалт зохион байгуулсан талаар:

Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд 2023 онд салбар зөвлөлийн 01, 08 дугаар тогтоолоор байгуулсан сонгон шалгаруулалтын комисс төрийн захиргааны гүйцэтгэх 10 албан тушаалын сул орон тооны 2 удаагийн тусгай шалгалтыг зохион байгууллаа.

Тэнцсэн иргэдийн 2 буюу 33.3 хувь төрийн албанаас түр чөлөөлөгдсөн иргэдийн нөөцөд бүртгэлтэй, 3 буюу 50 хувь нь 2020-2022 оны төрийн албаны ерөнхий шалгалтын нөөцөд бүртгэлтэй иргэд, 1 буюу 16.6 хувь төрийн жинхэнэ албан хаагч эзэлж байна.

Хүснэгт-2

№	Тусгай шалгалт зохион байгуулсан огноо	Тоо		Тайлбар
		Удирдах албан тушаал	Гүйцэтгэх албан тушаал	
1	2023.02.10		6	Нөхсөн 4, нөхөгдөөгүй 2 орон тоог нөхөөгүй.
2	2023.03.27		2	Нөхсөн 2.
	ДҮН		8	6 орон тоог нөхсөн, 2 орон тоог дахин зарлуулаад байна.

Тухайн албан тушаалын буюу тусгай шалгалтыг Төрийн албаны зөвлөлийн hh-admin.csc.gov.mn цахим системээр зохион байгуулж, сонгон шалгаруулалтын захиалга, зар оруулах, бүртгэх, шалгалт авах, дүнг мэдээлэх бүх үйл явц цахимаар явагдаж хэвшсэн.

Гурав. Бусад үйл ажиллагааны талаар:

Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайланг Төрийн албаны тухай хуулийн 74.1 дэх хэсэг, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасан чиг үүргийн дагуу нэгтгэн, байгууллагын даргын 01 дүгээр сарын 06-ны өдрийн 01/29 албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлага, аудитын газарт хугацаанд нь хүргүүлэв.

Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 01 дүгээр сарын 27-ны өдрийн 1 дүгээр хуралдаанаар салбар зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлэн, зөвлөлийн гишүүдийн гаргасан саналыг тусгаж, зөвлөлийн даргаар батлууллаа. Салбар зөвлөлийн төлөвлөгөөг 8 зорилтын хүрээнд 19 арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлуулав.

Төлөвлөгөөний дагуу төрийн захиргааны албан хаагчдад зэрэг дэв шинээр олгуулах, ахиулах саналын хүрээнд зэрэг дэв шинээр 17 (дэс түшмэл 14, ахлах түшмэл 2, эрхэлсэн түшмэл 1) дөтгөөр , ахиулах 45 (дэс 43, эрхэлсэн 2) нийт 62 албан хаагчийн бүртгэл судалгаа, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн 02 дугаар сарын 02, 17-ны өдрийн 01/226, 01/303 албан бичгээр Төрийн албаны зөвлөлд, 02 дугаар сарын 02-ны өдрийн 01/225 албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад тус тус хүргүүллээ.

Мөн салбар зөвлөлөөс байгуулсан сонгон шалгаруулалтын дүнг 2020-2023 оны 1 дүгээр улирлын дүнгээр, эрх бүхий байгууллагаас шинээр баталсан төрийн

албаны сонгон шалгаруулалтын болзол, журмын тухай танилцуулга, мэдээллийг бэлтгэн 03 дугаар сарын 31-ний өдрийн “мэдээллийн цаг”-аар нийт албан хаагчдад танхим болон цахимаар мэдээлсэн. Цаашид энэ мэдээллийг улирал тутам мэдээлж байх юм.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯТЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
САЛБАР ЗӨВЛӨЛ